

“ОЮУТНУУДЫН ӨДӨРЛӨГ 2017” БОЛОВ

Written by stockholm

Wednesday, 27 September 2017 12:13 - Last Updated Wednesday, 27 September 2017 12:43

Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа ЭСЯ, Швед дэх Монголын Залуучуудын Холбоо той хамтран Швед улсад сурч, ажиллаж амьдарч буй Монгол оюутан, залуусынхаа дунд “Мэдээ мэдээлэл, санал бодлоо солилцох одорлог” арга хэмжээг 2017 оны 9 дүгээр сарын 23-ны Бямба гарагт зохион байгуулав.

Одорлогийн үеэр “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн толов байдал, хоёр орны дипломат харилцаа” сэдвээр Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Элчин сайд М.Энхсайхан, “Хүсэмжит мэргэжил” сэдвээр Швед дэх Монголын Залуучуудын Холбооны тэргүүн Э.Мандухай, “Future of working: career, culture and environment” сэдвээр Hem design studio-ын санхүүгийн менежер Б.Энхтуяа нар илтгэл тавьж, “Даяарчлагдсан нийгэмд хүний эзлэх байр суурь, хандлага” сэдвийн хүрээнд оюутан залуустай чолоот хэлэлцүүлэг өрнүүлэв.



МОНГОЛ УЛСААС ШВЕДИЙН ВАНТ УЛСАД СУУГАА

ЭЛЧИН САЙДЫН ЯАМ